

1. ТЕЛЕВИЗИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН СУВГИЙН ТООГ НЭМЭГДҮҮЛЖ, ТЭДГЭЭРИЙГ ДУУ ДҮРСНИЙ ӨНДӨР ЧАНАРТАЙГААР ДАМЖУУЛАХ

ЗОРИЛГО

Телевизийн өргөн нэвтрүүлгийн сувгийн тоог нэмэгдүүлж тэдгээрийг дуу дүрсний өндөр чанартайгаар дамжуулан хэрэглэгчдэд хүргэх болон телевизийн удирдлага, хяналтын системийг нэвтрүүлэхэд оршино.

Бүх телевизүүдээс тоон технологиор боловсруулсан HD программ хүлээн авч телевизийн сүлжээгээр дамжуулах үйлчилгээний нягтруулагдсан урсгалыг бий болгох ба шаардлагатай бол түгээх сүлжээ рүү /KaTV, IPTV операторууд, хиймэл дагуулын систем/ түгээх радио телевизийн холболтын техникийн төв байгуулах

Байгаль цаг уур, техникийн саатлаас хиймэл дагуулын дохио тасардаг улс даяар ганц хиймэл дагуулын сүлжээтэй байгаа нь үндэсний радио телевизийн нэвтрүүлгийн найдвартай байдлыг хангаж чадахгүй байгаа тул орон нутгийн тоон станцыг техникийн төвтэй холбож чадах хиймэл дагуулын нөөц сүлжээг байгуулах.

Техникийн төв, Улаанбаатар хот, орон нутгийн Телевиз радиогийн станцууд, Улаанбаатар хотын нэг давтамжийн сүлжээний төхөөрөмжүүдийг хянах, удирдах шаардлагатай тул хяналт удирдлагын төвтэй болгох.

ХҮРЭХ ҮР, ДҮН

- Иргэд мэдээлэл хүлээн авах найдвартай сүлжээгээр хангагдана.
- Дэлхийн стандартад нийцсэн, чанартай телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ иргэдэд түгээх боломж бүрдэнэ.
- Мэдээллийн багтаамж, хүртээмж нэмэгдэх
- Телевиз, сувгуудаас ирж буй дуу, дүрсийн дохионы чанарыг бууруулахгүйгээр дамжуулна
- Удирдлага, хяналтын нэгдсэн системээр дамжуулан илүү үр ашигтай үйл ажиллагаа явуулах замаар үйл ажиллагааны зардлыг хэмнэх
- Удирдлага, хяналтын нэгдсэн системээр дамжуулан тоног төхөөрөмжийн гэмтэл, саатлын шалтгааныг хурдан илрүүлж шуурхай арга хэмжээ авах боломжтой болно.
- тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийгдээгүйн улмаас ашиглалтын хугацаа дууссан, сэлбэг хэрэгслийн гэмтэл их гарч жилд дунджаар 200 сая төгрөгний урсгал зардал, үзлэг үйлчилгээг хийж байна. Энэ зардал хэмнэгдэх болно.

8.182

тэрбум төгрөг

Төслийн бүтэц

- ✓ Тоног төхөөрөмж
- ✓ Сургалт
- ✓ Суурилуулалт
- ✓ Модулятор



- ✓ Дахин дамжуулах станцын хяналт удирдлагын системийг интернэт сүлжээнд оруулж, төвд хянах удирдлагын төвтэй болох боломжтой болно.
- ✓ Радио телевизийн нэвтрүүлгийн холболтын төв байгуулах боломжтой болж, программын чанар техникийн параметрийг хянах тохируулах боломжтой болно.
- ✓ Телевизүүдээс хүлээн авсан тоон программыг нэгтгэн телевизийн сүлжээгээр дамжуулах үйлчилгээний нягтруулагдсан урсгал (MPEG-TS) бий болгоно.
- ✓ Улаанбаатар хот, аймгийн төвүүдийн 51 станц Нэгдсэн удирдлага хяналттай болно.
- ✓ Үйлчилгээ эрхлэгчдэд эдийн засгийн хэмнэлт бий болно.